

Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгоход дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

- хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгохыг хүссэн албан бичиг;
- хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар (нотариатаар баталгаажуулсан байна.);
- импортоор оруулж ирсэн шинэ бол хөдлөх бүрэлдэхүүний техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах бичиг;
- ашиглагдаж байгаад импортоор оруулж ирсэн бол хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ, тухайн улсын эрх бүхий байгууллагаас техникийн шаардлага хангаж байгааг тодорхойлсон дүгнэлт, бүртгэлээс хассан тухай тодорхойлолт, тэмдэглэл;
- хөдлөх бүрэлдэхүүн нь техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсгийн дүгнэлт;
- бүртгэлийн гэрчилгээний төлбөр тушаасан баримт.